



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/133

Арвайхээр

### Г Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.2.8 дугаартай Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д зарцуулах төсөл арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/78 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д зарцуулах 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100290

Аймгийн Засаг даргын 2021 оны 03  
дугаар сарын 11-ны өдрийн 11 дүгээр  
захирамжийн хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН  
ХУУЛИЙН XIX.2.8 ДУГААРТАЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ /ӨВӨРХАНГАЙ/ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ**

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/
1	Хархорин нэгдсэн эмнэлэгт чих хамар хоолойн тоног төхөөрөмж	96000,0
2	Аймгийн БОЭТ, Хархорин нэгдсэн эмнэлэгт ариутгагч хаалга	19900,0
3	Хархорин нэгдсэн эмнэлэг, Богд, Бат-Өлзий, Хужирт, Есөнзүйл, Нарийнтээл, Баян-Өндөр, Бүрд, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Өлзийт, Төгрөг сумдын Эрүүл мэндийн төв, Арвайхээр сумын Уянсэтгэл өрхийн эмнэлэгт лаборторийн тоног төхөөрөмж	215850,0
4	Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, бүх өрх, сумдын эрүүл мэндийн төв, багийн эмнэлэгт зөөврийн, суурин компьютер	102400,0
5	Хархорин нэгдсэн эмнэлэг, бүх сумын Эрүүл мэндийн төвд эрчимт эмчилгээний функциональ ор	36000,0
6	Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хайрхандулаан, Тарагт, Хужирт, Уянга сумдын Эрүүл мэндийн төв, Уянга сумын Жаргалант багийн эмнэлэг, Арвайхээр сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмж	29850,0
	НИЙТ ДҮН	500000,0

-оо-